

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2020 ОНЫ АРАВДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 11 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 10 дугаар сарын 01-ээс 2020 оны 10 дугаар сарын 31-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 13 орны 24 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд түр ирэгчийн бүртгэл 5, хасалт 8, оршин суух зөвшөөрлийн хасалт 7 хийсэн байна.

Оршин суух зөвшөөрлийн хасалтыг Виз, зөвшөөрөл, харьятын газарт хийлгэсэн БНХАУ-ын 2 иргэний гарах-орох 2 удаагийн визийг хүчингүй болгосон.

Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд 1 төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан ба батлагдсан хяналт шалгалтын удирдамжийн дагуу Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумдын нутагт байрлах 5 аж ахуй нэгж, байгууллагад шалгалт хийхэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй БНХАУ-ын 29 иргэн, хөрөнгө оруулагч БНХАУ-ын 1 иргэн, цар тахалын улмаас нутаг буцаж чадахгүй байгаа “В” ангиллын визтэй БНХАУ-ын 9 иргэн, нийт БНХАУ-ын 39 иргэн хамрагдсан бөгөөд хяналт шалгалтын явцад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Мэдээллийн сангаас давхардсан тоогоор 44 орны 568 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба зөрчил илрээгүй байна.

Мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах ажлын хүрээнд Төв аймгийн хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэдийн судалгааг мэдээллийн сангаас шүүж, 2020 оны 10 дугаар сарын 15-нд Төв аймгийн ЗДТГ-ын хуулийн хэлтэст өгсөн. 10 дугаар сарын байдлаар Төв аймгийн хэмжээнд 9 орны 98 гадаадын иргэн албан болон хувийн хэргээр оршин сууж байна.

1.2. Зөрчил шалган шийдвэрлэлтийн талаар:

Тайлангийн хугацаанд гадаадын иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авагдаагүй байна.

1.3. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд 3 орны 5 гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг гүйцэтгэж албадан гаргасан тухай тодорхойлолтыг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

1.4. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд орох виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн үндэслэлээр улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэн байхгүй болно.

Мөн гарах-орох визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй, торгууль төлөх чадваргүй /мөнгөгүй/ зэрэг үндэслэлээр Монгол Улсын хилээр гаргаагүй гадаадын иргэн байхгүй.

Шүүх, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.5. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 1 орны 2 иргэнээр өргөдөл анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 4 /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2, хүний нөөцтэй холбоотой 2/ тушаал батлан гаргаж биелэлтийг тооцов.

Тус газрын 2020 оны 10 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүллээ:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж тогтоосон хугацаанд, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж мөн сарын 30-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст;

- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан талаарх илтгэх хуудсыг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, боловсролын талаарх судалгааг төвөөс ирүүлсэн загварын дагуу гаргаж 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн тус тус хүргүүлсэн.

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тайлант хугацаанд архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Бичиг хэрэгт 8 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 5 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 4 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв. Энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 27 албан хаагч байна. Үүнээс ээлжийн амралттай 1 байна. Декреттэй 1, хүүхэд асрах чөлөөтэй 4 албан хаагч байна.

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн цахим системд 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр тус газарт мэргэжилтнээр томилогдсон 2 албан хаагчийн мэдээллийг оруулсан.

Ёс зүйн хариуцлагын талонд арга хэмжээ авхуулсан албан хаагч байхгүй болно.

Төв газраас 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан терроризмтой тэмцэх сэдвээр зохион байгуулсан сургалтад тус газрын 14 албан хаагч хамрагдсан.

2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд “Ахлах түшмэл”-ийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч хамрагдан суралцаж байгаа.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас БНТажикстан Улсад зохион байгуулсан “Хилийн менежментийн сургалт” сэдэвт цахим сургалтад тус газрын 1 албан хаагч 2020 оны 09 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 23-ны өдрүүдэд хамрагдсан.

Аялал жуулчлалын газраас 2020 оны 10 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан “Харилцааны ур чадвар хандлагын хүч” сэдэвт сургалтад тус газрын 4 албан хаагч хамрагдсан.

2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын явагчийн танхимд “Архивын баримт үдэх аргачлал”-ын талаар сургалт зохион байгуулав. Тус сургалтаар АЗБХГ-ын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үүссэн баримтыг архивын нэгж болгон үдэх талаар 22 албан хаагчдад мэдээлэл хүргэв.

Түүнчлэн дэлхий дахинд “Ковид-19” цар тахалын халдварлалтын хэмжээ буурахгүй байгаатай холбогдуулан Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран уг халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр мөн өдөр сургалт зохион байгуулав. Уг сургалтаар тус албаны 2 албан хаагч цар тахалаас хамгаалах нэг удаагийн хувцас, хэрэгслэлийг хэрхэн зөв өмсөж, тайлах талаар сургалт орж албан хаагчдын сонирхосон асуултад хариулж, харилцан ярилцав.

Үүнээс гадна Тээврийн цагдаагийн албаны Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Архины хор хөнөөл” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулав.

2020 оны 10 дугаар сарын 29-өөс 30-ны өдрүүдэд Хойд бүс дэх газарт зохион байгуулагдсан Гадааддын иргэн, харьяатын газрын удирдах албан тушаалтан, хяналтын улсын байцаагчдын сургалт зөвөлгөөнд тус газрын 4 албан хаагч хамрагдсан болно.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 577,158,100 төгрөгийн санхүүжилт орсноос цалин хөлсөнд 359,569,961 төгрөг зарцуулсан ба ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 86,792,559 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 26,561,302 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2020.10.02-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 76,538,109 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2020.10.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 518,722,400 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 419,955,318 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас, визийн хуудас олгоогүй. Өссөн дүнгээр визийн тэмдэгтийн хураамж 42,752,350 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 2,655,431 төгрөг, байрны түрээс 28,657,500 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 19,637,000 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.

Бараа материалд өссөн дүнгээр 15,774,694 төгрөг /үүнээс Хөшигийн хөндий дахь нисэх оноцны буудалд байрлах тус газрын ажлын байранд лазер зүсэлттэй, акустик хавтангаар тохижилтын ажил, байгууллагын лого хийлгэх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 3,300,000 төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн данс руу шилжүүлж/-ийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Тус газрын албан нийгмийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж ажилласан болно.

Буянт-Ухаа дахь нисэх буудлын 4 дүгээр хоолой дээр байрлуулсан компьютер, принтер, паспорт уншигч төхөөрөмжүүдийг 2 дугаар хоолой руу шилжүүлж байрлуулан дотоод сүлжээнд холбон албаны үйл ажиллагаа хэвийн явуулахад бэлэн болгосон.

Газрын компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбоотойгоор тоног төхөөрөмжийн үнийн судалгааг илтгэх хуудсаар хүргүүлэв. Буянт-Ухаа нисэх буудлын ирэгч, явагчийн хяналтын камерийн бичлэгийг компьютер дээр хуулсан.

Мэдээллийн технологийн хэлтэсийн сүлжээний инженерийн хамт Төв аймгийн төлөөлөгчийн суурин компьютерийн дотоод сүлжээний гэмтэлийг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн дотоод сүлжээний 3, техник хэрэгслийн 8, нийт 11 дуудлага хүлээн авч засварласан болно.

Тайлант хугацаанд төвөөс цахим хурал зохион байгуулахад төхөөрөмжийг холбон хурлыг тасалдалгүй дамжуулсан болно.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2020 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдлын мэдээ, 10 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө болон шилэн дансанд холбогдох мэдээллийг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчилах танин мэдүүлэх зорилгоор биечлэн 9, утсаар 29 иргэнд зөвөлгөө мэдээлэл өгсөн байна.

Дөрөв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний талаар

Хөшигийн хөндий дэх нисэх онгоцны буудалд байрлах Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газрын ажлын байранд лазер зүсэлттэй, акустик хавтангаар тохижилтын ажил, байгууллагын лого хийлгэх ажил гүйцэтгэх гэрээг “Бат хангайн хишиг” ХХК-тай байгуулан ажиллаж байна.

Тав. Бусад

Ээлжийн ахлахууд “Буянт-Ухаа” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн 10:00 цагийн шуурхай хуралд тогтмол сууж хил хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилласан байна.

2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр төвөөс зохион байгуулсан спортын арга хэмжээнд тус газрын албан хаагчид амжилттай оролцлоо.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд энэ онд зохион байгуулахаар тусгасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт “Мон медикал” лабораторид 10 дугаар сарын 01-нээс 02-ны өдрүүдэд тус газрын нийт 25 албан хаагчдыг хамрууллаа.

“Ковид-19” халдвар авахаас урьдчилан сэргийлж нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслэлээр өдөр бүр албан хаагчдыг ханган ажиллаж байна.

Хоногийн мэдээг өглөө бүр 09-10 цагийн хооронд ХШДАБОНХ-т хүргүүлж ажилласан болно.

----oOo----